

Аймгийн Засаг даргын 2024 оны 30 дүгээр
сарын 30-ны өдрийн 41/31 дугаар
захирамжийн хавсралт



**ТӨВИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН
БАЙГУУЛЛАГУУДААР 2024 ОНД ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ
АЖЛЫН ЗАРДЛЫН ХУВААРЬ**

Д/д	Хэвлэл мэдээллийн байгууллагуудын нэр	Санхүүжилт (Мян.төг)
Орон нутгийн хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллага		
1	Өвөрхангай UNN.mn сайт	6,000,000
2	“Соёмбо” телевиз	4,000,000
3	“Хас” телевиз	6,000,000
4	“Арвайхээр чөлөөт суваг” телевиз	6,000,000
5	Гэгээнтэн телевиз	3,500,000
6	Өвөрхангай Uvlive.mn сайт	6,000,000
7	“Өвөрхангайн өнгө” сэтгүүл	5,000,000
8	“Өвөрхангайн мэдээ” сонин	5,000,000
9	“Ноён-Уул фм 87.9” богино долгионы радио	4,000,000
10	Монголын радиогийн сурвалжлагч	2,000,000
11	“Дөрвөн эрдэнэ хоёр эс” ХХК	3,000,000
Төвийн хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллага		
12	UBS телевиз	6,000,000
13	Монголын мэдээ сонин	3,500,000
Нийт		60,000,000



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/72

Арвайхээр сум

**Аймгийн аварга малчин өрх
нэмэлтээр шалгаруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 03/03 дугаар тогтоолын 2.4.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/608 дугаар захирамжаар батлагдсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал сүргээ чанаржуулан, ашиг шимийг нэмэгдүүлж, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж, мал аж ахуйг эрчимжүүлэх, газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар амжилт гаргасан нэр бүхий малчдыг “Аймгийн аварга малчин өрх”-өөр шалгаруулсныг хавсралтаар баталсугай.

2. “Аймгийн аварга малчин өрх”-ийг гэр бүлийн хамт үнэмлэх, энгэрийн тэмдэг, 500,000 (таван зуун мянга) төгрөгөөр шагнасугай.

3. “Аймгийн аварга малчин өрх”-ийн энгэрийн тэмдэг, үнэмлэх, шагналд шаардагдах 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0153